



**Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо**

ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН журам

2023 ОНЫ 08 САРЫН 16-НЫ
ӨДРӨЭС ХҮЧИН ТӨГӨЛДӨР
ҮЙЛЧИЛНЭ



“ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛ”-ИЙН ЖУРАМ

НЭГ. ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЗОРИЛГО, ҮҮРЭГ

Дасгалжуулагчдын зөвлөл, түүний зорилго, үүрэг нь:

- 1.1 Дасгалжуулагчдын зөвлөл нь (цаашид Зөвлөл гэх) МУССХ-ны (цаашид Холбоо гэх) дүрмийн 13.1 зүйлд заасан Удирдах Зөвлөлийн дэргэдэх дасгалжуулагчдаас бүрдсэн зөвлөл бөгөөд Удирдах Зөвлөлийн хуулийн хүрээнд олгосон итгэмжлэлээр зөвхөн дасгалжуулагчидтай холбоотой асуудлаар бусад этгээдийн өмнө холбоог төлөөлж болно.
- 1.2 Монгол улсад усан спортыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах, тамирчдын амжилтыг олон улсын түвшинд хүргэж, дасгалжуулагч, тамирчдын үр чадварыг дээшлүүлэх, дотоод гадаадын сургалтанд хамрагдаж үр чадвараа сайжруулахад нь бэлдэх, зөвлөх, туслаж дэмжих.
- 1.3 Дасгалжуулагчдын санал санаачлага болон эрх ашгаа хамгаалуулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх хүсэлтийг Холбооны Удирдах зөвлөл болон Их хуралд танилцуулж шийдвэрлүүлэх.
- 1.4 Зөвлөл нь бие даасан хуулийн этгээд биш бөгөөд Холбооны болон Зөвлөлийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

ХОЁР. ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

- 2.1 Зөвлөл нь МУССХ-ны холбооны дүрэм, журам, Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоол шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 2.2 Зөвлөлийн шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар гаргах бөгөөд зөвлөлийн дарга саналын давуу эрх эдлэхгүй.
- 2.3 Удирдах зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх аливаа асуудалд, тухайн асуудлаар цөөнх болсон



гишүүдийн зарчмын зөрүүтэй байр суурийг заавал танилцуулна.

2.4 Зөвлөл нь тодорхой нэг асуудлаар дасгалжуулагчдын дундаас ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

2.5 Зөвлөл нь Нийт дасгалжуулагчдын хурлаар хэлэлцүүлж, Удирдах зөвлөлөөр батлуулсан журам, үйл ажиллагааны үндсэн зарчимтай байна.

ГУРАВ. ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

3.1 Зөвлөл нь нийт дасгалжуулагчдын хурлаас сонгогдсон долоон (7) хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.2 Зөвлөлийн сонгуульт хугацаа дараагийн Холбооны Их хурал хуралдаж Зөвлөл шинээр бүрдснээр дуусгавар болно.

3.3 Зөвлөлийн гишүүн нь (цаашид гишүүн гэх) доорхи шаардлагыг хангасан байна:

- (а) Холбооны тухайн жилийн татвараа төлсөн байх
- (б) Холбооны гишүүн байгууллага, клубын дасгалжуулагч байх
- (в) 18 нас хүрсэн
- (г) Сэргээшийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх
- (д) Зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас багагүй байна.

3.4 Зөвлөлийн бүрэлдэхүүн гуравны хоёроос доошгүй ирцээр хуралдаж шийдвэрийг гаргана.

3.5 Зөвлөлийн шийдвэр гаргах эрх нь зөвлөлийн хуралд хадгалагдах бөгөөд шаардлагатай тохиолдолд хурлыг цахимаар явуулж болно.

3.6 Зөвлөлийн дарга нь Нийт дасгалжуулагчдын хурлаас Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгосон сонгуулийн дүн болон Зөвлөлийн даргыг сонгосон тухай хурлын шийдвэрийг Удирдах Зөвлөлд танилцуулж батлуулна.

3.7 Гишүүн хүндэтгэх шалтгааны улмаас биечлэн хуралдаа оролцох боломжгүй бол хэлэлцэж буй



асуудлаар гаргах шийдвэрт зөвлөлийн өөр нэг гишүүнээр төлөөлүүлж эсвэл урьдчилан бичгээр саналаа өгч оролцож болно.

3.8 Зөвлөлийн гишүүн зөвлөлд үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон тохиолдолд зөвлөлийн сонгуулийн дүнгээр эрэмблэгдсэн дарааллаар дараагийн нэр дэвшигчийг, тийм нэр дэвшигч байхгүй бол нөхөн сонгуулийг явуулж орны хүнийг тодруулна.

3.9 Зөвлөлийн гишүүд нэг удаа улиран сонгогдож болох бөгөөд дээд тал нь найман (8) жил тасралтгүй Зөвлөлийн гишүүнээр ажиллаж болно

ДӨРӨВ. ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛ, ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

Зөвлөл болон гишүүн доорхи эрх, үүргийг хүлээнэ:

4.1 Энэхүү дүрмийн Нэг дүгээр хэсэгт заасан зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлнэ

4.2 Холбооны гишүүн байгууллага, клубуудыг сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулахад нь дэмжин туслаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

4.3 Усан спортын шинэ онол, арга аргачлал болон тоног төхөөрөмж, техник технологийн дэвшлийг бэлтгэл дасгалжуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, энэ талаархи судалгаа шинжилгээний болон гарын авлага боловсруулах ажилд бүх талын дэмжлэг үзүүлэх.

4.4 Олон улсын чанартай наадам, тэмцээнд оролцох тамирчдыг Удирдах зөвлөлөөс баталсан" МУССХ-ны Олон улсын тэмцээнд оролцох тамирчдын сонгон шалгаруулалтын журам"-ын хүрээнд оролцогч талууд болох Тамирчдын зөвлөлийн төлөөллийг байлцуулан сонгох

4.5 Тамирчдын бэлтгэлжилтийг ханган оролцох дасгалжуулагчийг томилох, холбооны ЕНБДаргад танилцуулах.

4.5 Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтах тамирчид болон дасгалжуулагчдыг сонгон шалгаруулж шаардлагатай үед өөрчлөх, мөн нөхөн сонгож Удирдах зөвлөлөөр батлуулах.

4.6 Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургуулилтын төлөвлөгөөг гаргаж, мэргэжлийн өндөр түвшинд сургалт, дасгалжуулалтыг явуулах.



4.7 Дотоод гадаадын тэмцээнд гаргасан амжилт, алдаа дутагдлыг дүгнэн хэлэлцэж Удирдах зөвлөлд тайлагнах.

4.8 Аливаа этгээдээс бэлтгэл сургуулилт, дасгалжуулалт болон дасгалжуулагчийн сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан талаархи санал гомдлыг хэлэлцэж шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд Ёс зүйн зөвлөлд хүргүүлэн шийдвэрлүүлэх

4.9 Холбооны болон Ёс зүйн дүрмийг чанд мөрдөж, Олимпийн хөдөлгөөний шударга өрсөлдөөн, сэргээшийн эсрэг дүрмийг биелүүлэх.

4.10 Нийт дасгалжуулагчдын болон зөвлөлийн хуралд оролцох, шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн шийдвэрийг Удирдах Зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэх

4.11 Холбооны бусад зөвлөлүүдтэй нягт холбоотой ажиллаж, тэдний хүсэлтийн дагуу өөрт харьяалагдах мэдээлэл, тоон баримтыг гаргаж өгөх.

4.12 Зөвлөлийн дүрмээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, зөвлөлийн хурлыг дөрөв (4) болон түүнээс дээш удаа тасалсан, ёс зүйн зөрчил гаргасан гишүүнийг Зөвлөлийн эсвэл Ёс зүйн зөвлөлийн саналыг үндэслэн, Удирдах зөвлөлийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө чөлөөлж болно.

ДӨРӨВ. ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

4.1 МУССХ-ны дасгалжуулагчдын зөвлөлийн дарга нь Үндэсний шигшээ багийн Ахлах дасгалжуулагч болох бөгөөд МУССХ болон World Aquatics-ийн дүрэм журмыг мөрдөж ажиллана.

4.2 Зөвлөлийн дарга дараахи эрхтэй:

4.2.1 Дасгалжуулагчдын Зөвлөлийг удирдан зохион байгуулах, энэхүү журмын дагуу хуралдуулж, тодорхой асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх

4.2.2 Бэлтгэл, сургалт, цугларалтанд оролцохоор шалгарсан тамирчид дасгалжуулагчид дурьдсан хугацаанд ирээгүй тохиолдолд хасах, өөрчлөх

4.2.3 Зөвлөл шийдвэрлэн Тамирчид болон клубын дасгалжуулагчдыг төрийн болон холбооны шагналд нэр дэвшүүлэх саналаа өгөх.

4.2.4 Үндэсний шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид гадаадад бэлтгэл хийх, мэргэжил



дээшлүүлэхэд албан ёсны урилгыг үндэслэн саналаа МУССХ-ны Удирдах Зөвлөлд гаргах.

4.3 Зөвлөлийн дарга дараах үүрэгтэй:

4.3.1 Дотоод, гадаадын тэмцээн, хамтарсан бэлтгэл, сургалтанд оролцох тамирчин дасгалжуулагч нарын зохион байгуулалтыг биечлэн хариуцах.

4.3.2 Тамирчин дасгалжуулагчдын тэмцээн цугларалтанд оролцох бүрэлдэхүүний тухай Зөвлөлийн болон Ахлах дасгалжуулагчийн шийдвэрийг холбогдох клуб, байгууллагуудад албан ёсоор мэдэгдэх.

4.3.3 Шигшээ багийн тамирчид, шигшээ багт нэр дэвшсэн дасгалжуулагч тамирчдын амжилт, сахилга батын зөрчлийн улмаас өөрчлөх шаардлагатай үед саналаа МУССХ-ны Удирдах зөвлөлд оруулан шийдвэрлүүлэх.

ЗУРГАА. ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН СОНГУУЛЬ

6.1 Доорхи шаардлагыг хангасан дасгалжуулагчид, нийт дасгалжуулагчдын хуралд оролцох болон зөвлөлийн сонгуульд санал өгөх эрхтэй.

(а) 18 нас хүрсэн

(б) Холбооны гишүүн байгууллага, клубын дасгалжуулагч байх

(в) Холбооны тухайн жилийн татварыг төлсөн байх

(г) Аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас багагүй байна.

6.2 Зөвлөлийн гишүүн байх шаардлагыг хангасан ямар ч дасгалжуулагч өөрийн болон бусад дасгалжуулагчийн нэрийг Зөвлөлийн сонгуульд нэр дэвшүүлж болно.

6.3 Санал хураахаас өмнө Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч бүр таван (5) минутаас ихгүй хугацаанд өөрийгөө танилцуулах эрхтэй.

6.4 Дасгалжуулагчдын хурлын төлөөлөгч бүр саналын нэг эрхтэй.



6.5 Зөвлөлийн анхны сонгуульт хурал болон сонгуулийг Удирдах зөвлөлөөс нэг Дэд Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөлөөс томилогдсон нэг, ЕНБД гэсэн гурван хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулна.

6.6 Саналыг нууцаар хураах бөгөөд санал тооллогын дүнг комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан, Удирдах зөвлөлд танилцуулна.

6.7 Хамгийн олон санал авсан долоон (7) нэр дэвшигчийг зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно.

6.8 Санал тэнцсэн тохиолдолд тухайн нэр дэвшигчид дээр дахин санал хураалтыг зохион байгуулна.

ДОЛОО. НИЙТ ДАСГАЛЖУУЛАГЧДЫН БОЛОН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

7.1 Нийт Дасгалжуулагчдын хурлыг (цаашид Хурал гэх) жилд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд Удирдах зөвлөлтэй хэлэлцсний үндсэн дээр 14 хоногоос доошгүй хугацааны өмнө тов болон хэлэлцэх асуудлыг нийт дасгалжуулагчдад мэдээлнэ.

7.2 Дасгалжуулагчдын зөвлөлийн ээлжит хурал цахим хэлбэрээр хуралдаж болно.

7.3 Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хурлыг зохион байгуулах хүсэлтийг гаргаж Удирдах зөвлөлд гаргаж болно.

5.4 Хурлыг Зөвлөлийн дарга удирдах бөгөөд Зөвлөлийн сонгуульт жил Хурал даргалагчийг ил санал хураалтаар, нийт оролцогчдын ердийн олонхийн саналаар сонгоно.

5.5 Хурлыг зохион байгуулах ажилд ЕНБД болон Удирдах зөвлөлөөс томилогдсон гишүүн оролцоно.

5.7 Хурлын тэмдэглэл болон гаргасан шийдвэрийн хувийг ЕНБД хүргүүлнэ.

НАЙМ. БУСАД

8.1 Энэхүү журам нь МУССХ-ны Удирдах зөвлөл баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.2 Зөвлөлийн журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг МУССХ-ны Удирдах зөвлөлөөр хэлэлцэж батална.